

**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАВЬЯАТ АЖИЛТАН  
Я.ШАРАВДОРЖИЙН НЭРЭМЖИТ ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 5-15

Мөрөн

Ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай

Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.2, 23.2.3 дахь заалт, “Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, ЗГ-ын 2014 оны 332 дугаар тогтоол зэргийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хатгал” ус, цаг уурын өртөөний дарга Ганхуяг овогтой Өлзийням, “Тосонцэнгэл” ХАА-н цаг уурын харуулын ажиглагч Баттулга овогтой Баярмаа нарын хөдөлмөрийн гэрээг 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлж, мөн өдрөөс Г.Өлзийнямыг “Тосонцэнгэл” ХАА-н цаг уурын харуулын ажиглагчаар, Б.Баярмааг “Хатгал” ус, цаг уурын өртөөний техникчээр тус тус томилон хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж ажиллуулсугай.

2. “Хатгал” ус, цаг уурын өртөөний техникч Алиажий овогтой Отгоннямын хөдөлмөрийн гэрээг 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлж, мөн өдрөөс тус өртөөний даргын үүрэг гүйцэтгэгчээр томилон, хөдөлмөрийн хугацаатай гэрээг шинэчлэн байгуулж ажиллуулсугай.

3. Б.Баярмаагийн цалинг өмнө авч байсан буюу төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээний дагуу ТҮ-6-1 шатлалаар 496912 /Дөрвөн зуун ерэн зургаан мянга есөн зуун арван хоёр/, Г.Өлзийнямын цалинг ТҮ-6-1 шатлалын дагуу 496912 /Дөрвөн зуун ерэн зургаан мянга есөн зуун арван хоёр/, А.Отгоннямын цалинг ТҮ-7-3 шатлалын дагуу 550369 /Таван зуун тавин мянга гурван зуун жаран ес/ төгрөгөөр тус тус тогтоосугай.

4. Г.Өлзийням, Б.Баярмаа, А.Отгонням нарын ажлын байрны тодорхойлолтонд заасан үүрэгт ажилд зааварчлага өгч, хяналт тавьж ажиллахыг цаг уурын технологич инженер Э.Баяржаргал, ХАА-н цаг уурын технологич инженер Л.Байгальмаа, ЦУОТХ-ийн дарга Б.Өнөрбат нарт үүрэг болгосугай.

ДАРГА



А.ҮНЭНБАЯР